**МОНГОЛ УЛСЫН**
**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ**
**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2022 оны 07 сарын 06 өдөр Дугаар Б/87 Улаанбаатар хот

Төрийн албанаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 46.3, 60 дугаар зүйлийн 60.1, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай” хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Автотээврийн стандартчилал, техникийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Жамъянгаравын Нарантунгалагийг өөрийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан 2022 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн төрийн албанаас чөлөөлсүгэй.

2.Ж.Нарантунгалагийн албан тушаалын нэг сарын үндсэн цалин болох 1,283,967 (нэг сая хоёр зуун наян гурван мянга есөн зуун жаран долоо) төгрөгийг төрийн албанд ажилласан 27 жилийг нь харгалзан 27 сараар үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосугай.

3.Буцалтгүй тусламжид шаардагдах 34,667,109.0 (гучин дөрвөн сая зургаан зуун жаран долоон мянга нэг зуун ес) төгрөгийг зохих сангаас олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

4.Ж.Нарантунгалагийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ё.Жаргалсайхан)-т, холбогдох санхүүгийн тооцоог хийж дуусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т тус тус үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

9020050420 5919487 СБА7589

080000608